



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Баянтоорой багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/189/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn “Ариун төгс оршихуй аудит” ХХК-ийн Ахлах аудитор: Ч.Сэлэнгэ Утас: 99023656 Цахим хаяг: ariuntugsorshihuiaudit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 21 № 39

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт сумын Баянтоорой тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цогт сумын Баянтоорой тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Чиглэл батлах тухай" 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 276,914.0 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд хандив болон бусад эх үүсвэрээс 4,276.8 төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 15 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 48 арга хэмжээг 100.0 хувь, 10 арга хэмжээг 67.9 хувь буюу нийт дүнгээр 84 хувиар биелүүлж биелэлтийг хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

07020127

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	131,059.00	288,869.80
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,388,805.30	1,291,302.30
Нийт хөрөнгийн дүн	1,519,864.30	1,580,172.10
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,519,864.30	1,580,172.10
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,519,864.30	1,580,172.10
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,380,491.80	1,103,963.90
Үйл ажиллагааны зардлын дүн	860,427.50	1,043,656.10
Үйл ажиллагааны үр дүн	1,520,064.30	60,307.80
Үйл ажиллагааны бус үр дүн	-200	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	1,519,864.30	60,307.80
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,519,864.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Тайлант оны үр дүн	1,519,864.30	60,307.80
Эцсийн үлдэгдэл	1,519,864.30	1,580,172.10
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	855,798.10	1,095,345.90
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	800,552.60	973,795.80
Үйл ажиллагааны ЦМГ	55,245.50	121,550.10
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-20,528.00	-
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	34,717.50	121,550.10
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	34,717.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,717.50	156,267.60
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	973,775.80
Урсгал зардал	-	973,775.80
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,095,325.90
Улсын төсвөөс санхүүжих	-	1,023,640.60
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	56,705.00
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	14,980.30
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	156,267.60

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 15.8 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Монголын цахилгаан холбоо ХК-тай байгуулсан гэрээний дагуу 15.1 сая төгрөгийг шилжүүлсэн боловч тухайн хөрөнгийг ирээгүй байхад орлого авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ";, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтыг зөрчсөн байна.
- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн үр дүнгийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлыг 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 11.2 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 11.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 10.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 0.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 албан шаардлага өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Цалингийн зардлаас тэтгэвэрт гарсан 2 албан хаагчид 10.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", төрийн хэмнэлтийн тухай 11 дүгээр зүйлийн 11.1-д "Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэтгэвэрт гарсан албан хаагчдад олгосон тэтгэмжийг орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Сургуулийн захиралд 2023 оны 7 дугаар сард олгосон 0.5 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.2. Албан шаардлага

- Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж үдийн цайны зардлаас 0.08 сая төгрөгийн хоол, хүнсний материал авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

- Цалингийн зардлаас 0.6 сая төгрөгийн ажлын хөлсийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", төрийн хэмнэлтийн тухай 11 дүгээр зүйлийн 11.1-д "Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цогт сумын Баянтоорой багийн Ерөнхий боловсролын сургууль		.8				.8		.8			-	-
Дүн		.8	-	-		.8		.8		-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цогт сумын Баянтоорой багийн Ерөнхий боловсролын сургууль	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цогт сумын Баянтоорой багийн Ерөнхий боловсролын сургууль		.2		10.5		0.7	-	-	-	-	-	-
Дүн	4	11.2	2	10.5	2	0.7	-		-	-		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1		-	-
	НИЙТ	1	1	-	-	1		-	-